



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/265 тоот захирамж, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд ажлын байранд ирж ажиллах нийт ажилтнуудын 5% буюу 4 албан хаагчдын нэрс, ажиллах хуваарийг нэгдүгээр хавсралтаар, 0-12 насны хүүхэдтэй цахимаар ажиллах эмэгтэй албан хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, бусад ажилтнуудыг цахимаар ажилуулсугай.

2. Цахимаар ажиллах ажилтнуудыг үүрэгжүүлж, ажлын цаг ашиглалт болон ажлын гүйцэтгэлд өдөр бүр хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг хэлтсийн дарга нарт (Л.Эрдэнэбат, Л.Ганбат, Э.Энхбаяр, Ш.Энхжаргал, Э.Уянга, Г.Уранбайгал, В.Мөнхжаргал, Б.Гүнжидмаа) даалгасугай.

3. Хариуцсан хэлтсүүдийн төлөвлөгөөт ажлыг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан чанартай гүйцэтгүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан), Судалгаа хариуцсан орлогч дарга (С.Очир-Эрдэнэ), Ерөнхий инженер (Ж.Баясгалан) нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА